

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДРИЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬ!

Монгол Улсынхаа төлөө зүтгэе!

Монгол Улсын 2010, 2013, 2014 оны салбарын шилдэг сонин



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.03.16 №10, 11 (10687, 10688)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

МЭНДЧИЛГЭЭ



Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, сонсогч нартаа, даян дэлхийд энхийг сахиулж яваа цэнхэр дуулгатнуудаа, дайнд оролцож, дэрийн утаа үнэртсэн хүндэт буурлууд, ахмад дайчдаа, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн та бүхэнд "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 99 жилийн ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Монгол цэргийн түүх нь Монгол Улсын тусгаар тогтнолын түүх юм. Монголчууд эрт цагаас цэрэг-захиргааны нэгдмэл тогтолцоотой байж, газар нутаг, тусгаар тогтнолоо цэргийн хүчээр хамгаалсаар ирсэн бөгөөд цэрэг эрсийнхээ сүр хүч, сүлд хийморьт шүтэж, тэднийхээ алдар гавьяа, амжилт ололтыг бахархан дуурайж ирсэн билээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар хурлын тогтоолоор Монгол Ардын журамт цэрэг Хиагт хотыг чөлөөлж анхны ялалтаа байгуулсан 3 дугаар сарын 18-ны өдрийг "Хувьсгалт цэргийн баярын өдөр" болгон жил бүр улс нийтээр ёслон тэмдэглэх шийдвэр гаргаж, энэ өдрийг цэргийн алба хаагчдын амралтын өдөр болгосон байдаг.

Монгол Улсын Их Хурлаас "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай" хуульд 2011 онд нэмэлт өөрчлөлт оруулж, жил бүрийн энэ өдрийг "Монгол цэргийн өдөр" болгон тэмдэглэж эхэлсэн юм.

Энэхүү баяр чухамдаа улс орныхоо тусгаар тогтнол, ард түмнийхээ эрх чөлөөг хамгаалан тэмцсэн түүх, үе үеийн эх орончид, цэрэг дайчдынхаа гавьяат үйлсээр бахархах, өсвөр, залуу үеийн эх оронч сэтгэлийг нь дэврээх, эх орноо гэсэн хүсэл эрмэлзэл, хайрлан хамгаалах үзэл бодлоор цэнэглэхэд үлгэр дуурайл үзүүлэх чухал ач холбогдолтой билээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, цэрэг эрс маань өнгөрсөн зуунаас эдүгээг түүчээлэн улс орноо батлан хамгаалах нэн хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үүргийг амжилттай гүйцэтгэж, эх орныхоо нэр хүндийг олон улсын тавцанаа дуурсган эх дэлхийн энх тайван, амар амгаланг тогтоох үйлсэд эр зориг, тэсвэр хатуужил, мэргэжлийн ур чадвараа гайхуулан байгаа бахархам гавьяа, бахдам амжилтыг баярын энэ өдөр тэмдэглэхэд таатай байна. Улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний шинэчлэлийг эрчимжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангахад чиглэгдсэн олон ажлыг хийж гүйцэтгэлээ.

Улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний оролцоо оролцоо, үйл ажиллагааны цар хүрээ өсөн нэмэгдсэнтэй холбогдуулан цэргийн алба хаагч, техник хэрэгслийг бүтээн байгуулалтад оролцуулах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах нэгжийг Зэвсэгт хүчний тайван цагийн бүтцэд бий болгосны зэрэгцээ кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүллээ. Цаашид барилга, инженерийн төрлийн цэрэг, кибер аюулгүй байдлын мэргэжлийн цэрэгтэй болох эрх зүйн суурийг тавилаа.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2050 болон уг бодлогыг 2020-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлж бэхжүүлэх зорилго, зорилтуудыг тодорхойллоо. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу "Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г анх удаа батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Цаашид ч улс орны батлан хамгаалах чадавх, аюулгүй байдлын баталгааг нэмэгдүүлэх, төрийн цэргийн байгууллагуудын нэгдмэл тогтолцоог боловсронгуй болгох, алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг дээшлүүлэх чиглэлээр олон ажлыг та бүхэнтэйгээ хамтран шийдвэрлэх болно.

Олон зууны баялаг түүх, орчин үеийн шинэ шинэ ололт амжилтаар түүхийн хуудсаа зузаатган, хөгжин бэхжиж буй Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний яруу алдар өнө мөнхөд мандан бадрах болтугай!

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГТ ХАНДИВ ӨРГӨВ

Дэлхийн олон улсад тархаж байгаа халдварт "COVID-19" вирусийн тархалт цар тахлын хэмжээнд хүрч, хүндэрч байгаатай холбогдуулан ЗХЖШ-ын Энхийг дэмжих-цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн санаачилгаар ЗХЖШ-ын бүрэлдэхүүн, БНӨСҮ-д явагдаж байгаа НҮБ-ын "UN-MISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа болон ИБНАУ-д явагдаж байгаа "Шийдвэртэй дэмжлэг" олон улсын ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж буй цэргийн багуудын 1000 гаруй цэргийн алба хаагчийн сэтгэлийн дэмээр бүрдсэн 12,6 сая гаруй төгрөгийг үнэ бүхий хамгаалах хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, уусмалыг Цэргийн төв эмнэлгийн урьдчилан сэргийлэх, тусгаарлах байранд ажиллаж байгаа эмч, сувиллагч, эмнэлгийн ажилтнууд, ажиглалтад байгаа иргэдэд гардуулан



өглөө. Эдгээрийг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч, хурандаа Ц.Жавхланбаатар, ЭДЦХАХ-ийн дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ болон БНӨСҮ-д үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн алба хаагчдын ар гэрийн төлөөлөл Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч, хурандаа С.Батболдод гардуулан өгсөн юм.

ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН СУМДАД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙХЭН АЖИЛЛАЖ БАЙНА



ЗХЖШ-ын даргын тушаалаар өвөлжилт хүндэрсэн Завхан аймгийн Баянтэс, Тэс, Нөмрөг, Баянхайрхан, Асгат, Тосонцэнгэл, Их уул, Хөвсгөл аймгийн Галт, Жаргалант, Шинэ-Идэр, Цэцэрлэг суманд энэ сарын 8-ны өдрөөс эхлэн Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн тусгай томилгоот бүрэлдэхүүн таван нэгж техникээр өвс, тэжээл хүргэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үүрэг гүйцэтгэж байна.

Аймгийн онцгой комиссын мэдээлснээр

хөрсөн дээр -34 хэм хүйтэрсэн, нутаг дэвсгэрийн 60 орчим хувь нь цагаан зудад нэрвэгдсэн, 3 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд цагаарын байдал цасан шуургатай, цасны зузаан аймгийн урд хэсгээр 30-40 см, хойд хэсгээр 50-60 см хүрч байгаа аж. Цаг агаар хүндэрсэн эдгээр сумдад үүрэг гүйцэтгэж байгаа Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн тусгай томилгоот бүрэлдэхүүн нь цаг ямагт автомашины бэлэн байдлыг хангаж, аюулгүйн ажиллагааны зааварчилгааг мөрдөн ажиллаж байна. Хэдийгээр уул даваа, цас ихтэй газарт үүрэг гүйцэтгэхэд бага хэмжээний эвдрэл, гэмтэл гарч байгаа хэдий ч малчдад өвс, тэжээл хүргэх ажлыг бие бүрэлдэхүүн амжилттай гүйцэтгэсээр байна.

БАХАРХАХ ҮЙЛСИЙН ЭЗЭН БААТАР ГЕНЕРАЛ АА ТЭЖ ...

Биднийг 1980-аад оны сүүлчээр Цэргийн Нэгдсэн Дээд Сургуульд суралцаж байх хугацаанд тус сургуулийн захирлаар хошууч генерал Д.Бямбацогт, захирлын 1 дүгээр орлогч бөгөөд Сургалтын хэлтсийн даргаар хошууч генерал Т.Баатар томилогдон ирж билээ. Алтан мөрдөстэй тэрхүү генералуудыг ирсэн өдрөөс л сургуулийн бүхий л үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт гарч, өнөөгийн Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн Соёлын төв, Номын сан, Цэргийн нэгдсэн сургуулийн хичээлийн байрны шав тавигдаж, сургалт, эрдэм шинжилгээний ажилд ахиц гарч, аливаа хууль, дүрэм, журмууд нийт багш, рот, курсийн захирагч, сонсогчдод жигд үйлчлэх болсны хамт ар тал, ахуй хангалт, тохижилт, үйлчилгээ, хоолны амт чанар мэдэгдэхүйц дээшилсэн юм.



Тухайн үед зуны нэг сар, өвлийн 14 хоногийн амралтаас бусад хугацаанд цэргийн хурандаа "амьдардаг" сонсогч бидний мөнхийн мөрөөдөл эрхэм генералуудын буянаар биелэгдэж байсныг эргэн дурсахад юутай бахдалтай. Тэр хоёр биднийг сургуулийн жагсаалын талбайд жагсааж санал авах үед нь шинэ байр, танхимтай болох, сонсогчдыг гадуур суралцуулдаг болгох гэсэн санал голчилсон нь үнэн түүх юм. Энэ л санал асуулгын дараагаар төгсөх курсийн сонсогчид гадуур амьдрах болж, зургаан өдөр хичээллэж, ганцхан бүтэн сайн өдөр амардаг байсан бид Ням гарагийн өглөө Шархад дахь Сургалтын төв рүү гүйж, рот, курсээрээ хамрагдан журамласан жагсаалаар бүрэн орж ирвээс тэр өдрөө чөлөөгөөр гардаг тогтолцоонд шилжиж бидний тэрхүү мөрөөдөл биелсэн юм даа. Энэ мэт цөөнгүй дурсамжийг хүндэтгэн

өгүүлэх олон арван офицерууд өнөөдөр ч Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийхээ хөгжил дэвшилд хоёргүй сэтгэлээр жинтэй хувь нэмрээ оруулсаар явна.

Цэргийн сэтгүүлчдийн эгнээнд багтаж, олон арван алдартнууд, нэн ялангуяа ахмад үеийнхний алдар гавьяа, амжилт бүтээл, ажлын туршлагыг нь магтан дуулсан нийтлэлийг хэдэнтээ тэрлэсэн миний хувьд цаашид ч хэд хэдэн гавьяатнуудын талаар дурсамж тэрлэх чин хүсэлтэй явдаг юм. Тэдний нэг нь өөрийн амьдрал, ажил хөдөлмөрөөрөө хэн бүхний танил болж, төрдөө дээдлэгдэн хүндлэгдсэн, түмэн олондоо бишрэгдэн алдаршсан, бахдам амжилт, бахархам үйлсийн эзэн, чөлөөнд байгаа хошууч генерал Тавхайн Баатар юм.

(Үргэлжлэл нь VII нүүрт)

АНУ-ЫН ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ДАМЖААНЫ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

2020-2021 оны хичээлийн жилд АНУ-ын “Гадаадын цэргийн боловсрол, сургалтын хөтөлбөр”-өөс санхүүжүүлж, зохион байгуулагдах дараах сургалт, дамжаанд суралцах хүсэлтэй цэргийн алба хаагчдад сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж байна. Үүнд:

Д/д	Сургалт, дамжаа	Эхлэх огноо	Дуусах огноо	Шаардлагатай оноо /ECL/	Тайлбар
1.	Иргэн-цэргийн харилцааны сургалт	2020.04.07	2021.01.13	80	Тус бүр нэг цэргийн алба хаагч
2.	Явган цэргийн офицерын анхан шатны дамжаа	2020.06.02	2021.01.22	75	
3.	Цэргийн тагнуулын офицерын анхан шатны дамжаа	2020.05.12	2020.12.03	70	
4.	Холбооны офицерын ахмадын дамжаа	2020.06.23	2020.11.24	80	
5.	Кибер аюулгүй байдлын дамжаа	2020.06.16	Тодорхойгүй	85	
6.	Инженерийн офицерын анхан шатны дамжаа	2020.05.05	2021.01.20	75	

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор хүсэлтээ анги, байгууллагын удирдлагаараа уламжлуулан ЗХЖШ-ын Хүний

нөөцийн хэлтэст ирүүлсэн байна. Сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчдыг 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 09.00 цагт англи хэлний түвшин тогтоох шалгалтад хамруулна.

АХМАДУУДАА УРИАЛЖ БАЙНА

Дэлхий нийтэд тархаад буй шинэ төрлийн коронавирусийн нөхцөл байдлаас шалтгаалж өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын Ерөнхий газар, Цэргийн төв эмнэлэг зэрэг төрийн байгууллагын алба хаагчдад туслах хандивын арга хэмжээ улсын хэмжээнд өрнөөд байна. Үүнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний анги, байгууллага, алба хаагчид ч идэвхтэй оролцож хэрэгтэй газар нь шаардлагатай зүйлсээр тусалцаж байна.

Тухайлбал, Барилгын цэргийн 158 дугаар ангийн Ахмадын хорооны тэргүүн, чөлөөнд байгаа бэлтгэл дэд хурандаа Ц.Дагвадорж, гүйцэтгэх захирал, бэлтгэл хошууч О.Бямбасүрэн нарын ахмадууд нэг удаагийн 500 ширхэг амны хаалт, 200 ширхэг бээлийг Цэргийн төв эмнэлгийн

дарга, ерөнхий эмч, хурандаа С.Батболдод гардуулан өглөө. Ахмадууд энэ үеэр “Цэргийн эмнэлгийн үүрэг хүлээсэн эмч,

байгаарай гэсэн үгднээс энэхүү нэг удаагийн амны хаалт, бээлийг өгч байна. Үүгээрээ дамжуулан бусад ахмадуудаа



ажилтнууд та бүхнийг дэлхий нийтэд тархаад байгаа аюул өвчний үед өөрсдийн эрүүл мэндийг сайтар хамгаалж

ч хандивын үйлсэд идэвхтэй оролцохыг уриалж байгаагаа “Соёмбо” сониндор дамжуулж байна гэсэн” юм.

НАНДИН БҮХНЭЭ БИЧСЭН ЗАХИДЛУУД ЭЗДЭДЭЭ ОЧИВ



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ИБНАУ-д явагдаж буй “Шийдвэртэй дамжлэг ажиллагаанд ХБНГУ-ын

Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XI ээлжийн цэргийн баг “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг амжилттай зохион байгууллаа.


Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 110 гаруй энхийг сахиулагч ижийдээ захидал бичсэнээс шалгарсан дөрвөн захидлыг МҮОНТ-ийн “Ижийдээ захидал бичээрэй” уралдаанд мөн 10 захидлыг нь ЗХЖШ-т илгээсэн юм. Эдгээр захидлыг ЗХЖШ-ын ЭДЦХАХ-ийн дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ИЦХХ-ийн дарга, хурандаа С.Төмөрхуяг нар эх орондоо охиноо, хүүгээ хүлээж байгаа ээжүүдэд нь гардуулан өглөө. Тэр бүр хэлж чаддаггүй сэтгэлийн гүнд хадгалагдаж байдаг нандин үгсээ сийрүүлэн бичсэн энэхүү захидал ээжүүдэд нь хамгаас эрхэм, нандин бэлэг болов. Захидлаа гардан аваад ижий бүр догдолж, дугтуйгаа задлан уншихдаа нулимс дуслуулан албаа нэр төртэй хааж байгаа хүүгээрээ, охиноороо бахархаж байсан юм.

Манай сурвалжлагч мэдээлж байна

СУДАН БҮСГҮЙЧҮҮДИЙГ БАЯРЛУУЛАВ

БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобуудлын батальон “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан 3 дугаар сарын 6-ны өдөр эргүүлийн үүрэг

нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, урлагийн тоглолт, орон нутгийн эмэгтэйчүүдийн гар урлалын үзэсгэлэн худалдаа зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагааг зохион байгуулав. Энэ үеэр цэргийн баг иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх



гүйцэтгэх үедээ орон нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болсон мод, модны нүүрс бэлтгэдэг бүсэд орон нутгийн 50 гаруй эмэгтэйг баярлуулав. Энэ үеэр тэдэнд зориулан хэвлэж бэлтгэсэн “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн мэндчилгээг тараахын зэрэгцээ баяр хүргэж, хээрийн цайгаар дайж, ахуй амьдрал, НҮБ-ын цэргийн үйл ажиллагааны талаарх сэтгэгдлийг нь сонсож, гар, хумс арчлах талаар зөвлөгөө өгч, халуун дотно яриа өрнүүлээ.

Энэ үеэр тэдний дунд байсан жирэмсэн эхэд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн юм. Орон нутгийн эмэгтэйчүүд НҮБ-ын цэргийн үйл ажиллагаанд ялангуяа Монголын цэргийн алба хаагчдын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байдгаа илэрхийллээ. Та бүхэн бидэнд аюулгүй байдал, итгэл найдварыг төрүүлдэг, бид чадлаараа та бүгдийн үйл ажиллагааг дэмжих болно хэмээн тэд сэтгэгдлээ илэрхийлэн үндэснийхээ ая дуугаар мэндчилгээ дэвшүүлсэн.

Мөн тус баярыг тохиолдуулан Юнити секторын мужийн зохицуулалтын албанаас 3 дугаар сарын 9-ний өдөр Бентью хотын эмэгтэйчүүд, иргэдтэй баярын арга хэмжээг зохион байгуулж, эмэгтэйчүүдийн эрх, тэдний нийгмийн идэвх, оролцоо,

ажлын хүрээнд 47 цэргийн алба хаагчийн бүрэлдэхүүнтэй урлаг, соёлын дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.

Арга хэмжээнд Юнити секторын мужийн зохицуулагч хатагтай Хироко Хирохара, НҮБ, олон улсын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөлөл, Юнити секторт үүрэг гүйцэтгэж буй НҮБ-д цэрэг хандивлагч орнуудын цэрэг, цагдаагийн бүрэлдэхүүний төлөөлөл, орон нутгийн эмэгтэйчүүд, иргэд зэрэг 500 орчим хүн оролцов. Арга хэмжээ Бентью хотын төв гудамжаар НҮБ-ын эмэгтэй ажилтнууд, НҮБ-ын цэрэг, цагдаагийн эмэгтэй алба хаагчид, орон нутгийн эмэгтэйчүүд оролцсон үлээвэр хөгжимтэй эв санааны жагсаалаар эхэлсэн юм.

Мөн цэргийн багийн үлээвэр хөгжимчид болон урлагийн бүрэлдэхүүн Монгол Улсынхаа урлаг, соёлыг НҮБ-ын цэрэг, цагдаагийн алба хаагчид, ажилтнууд, орон нутгийн иргэдэд сурталчиллаа. Урлагийн арга хэмжээнд “Их хүндэтгэл” бүжиг, морин хуурын болон монгол ардын уртын дуу, англи дуу, язгуур урлагийн төрлүүдээс бүрдсэн хэсэгчилсэн тоглолтыг толилуулсан бөгөөд хүндэт зочид, орон нутгийн иргэд өндөр сэтгэгдэлтэй хүлээн авч, урлагийн тоглолтод оролцсон алба хаагчдад талархал илэрхийлж байв.

Ахмад Д.МЭНДБАЯР

Монгол цэргийн музей

“БҮХНИЙГ ФРОНТОД, БҮХНИЙГ ЯЛАЛТЫН ТӨЛӨӨ” ...

Монгол цэргийн музей нь Аугаа их Эх орны дайны ялалтын болон 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан Оросын Холбооны Улсын Зэвсэгт хүчний харьяа цэрэг, эх орны “Патриот” соёл амралтын хүрээлэнд 2020 оны 2 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд “Бүхнийг фронтод, бүгдийг ялалтын төлөө” нүүдлийн хамтарсан үзэсгэлэнг гаргалаа.

Тус үзэсгэлэнг БНМАУ Аугаа их Эх орны дайны эхний өдрөөс фашист Германыг үг дуугүй бууж өгөх үе хүртэл ЗХУ-ын найдвартай ар тал нь болж зургаан удаа илгээж байсан бэлгийн цувааны талаарх түүхэн үнэнийг өгүүлэх архивын баримт бичиг дээр тулгуурлан гаргажээ. Үзэсгэлэнд нь Эх орны дайны жилүүдэд БНМАУ-аас ЗХУ-ын их, дээд, дунд сургуульд

суралцаж байсан монгол иргэдийн тухай болон тэдний Киев хотын хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байсан тухай өмнө нь олны хүртээл болж байгаагүй архивын баримт материалыг дэлгэсэн аж. Уг үзэсгэлэнгийн нээлтийн үеэр “Патриот” соёл амралтын хүрээлэнгийн захирал, хурандаа Игорь Александрович Барсков, Монгол Улсын Батлан хамгаалах яамны харьяа Монгол цэргийн музейн захирал, хурандаа Д.Ганзориг нар хоёр талын хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байна. Цаашид Аугаа их Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн баярын арга хэмжээний үеэр Японы эсрэг дайнд оролцсон 22 улсын төлөөлөгчдийг оролцуулсан “Милитарист Японыг ялсан нь” байнгын үзүүлэнг дэглэхээр ажиллаж байгаа аж.

БЯЦХАН ОХИНД АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ

Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн салааны ахлагч, ахлах ахлагч Ч.Намхайдоржийн охин Н.Ригидмаа нь 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Улаанбаатар хотод мэндэлсэн. Бяцхан охин Н.Ригидмаа нь төрөлхийн уушигны венийн гуравдугаар судас нь буруу оролттой, тосгуур хоорондын таславхийн хоёр дахь нь цоорхойтой, зүүн тосгуурандаа хуурамч ховхлоготой гэсэн оноштойгоор БНЭУ-ын Шинэ Дэли хотын төв эмнэлэгт нэн яаралтай хагалгаанд орох шаардлагатай байгаа юм. Эмчилгээ нь 65.000.000 төгрөгийн өртөгтэй бөгөөд мөрдэс нэгт цэргийн

алба хаагчид та бүхэн чин сэтгэлийн хандив өргөж, бяцхан охин Н.Ригидмаад амьдрал бэлэглэхийг уриалж байна.

Холбоо барих утас:

Аав Ч.Намхайдорж 89110985

Ээж О.Саранзаяа 80120730

Хандивын данс:

Төрийн банк 101100531485

Хаан банк: 5129010359

Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн хамт олноос

ХУЛГАЙН ЗАМААР ЯВАХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА

Монгол Улсад коронавирусийн тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан УОК-ын хурлын шийдвэрээр аймаг, хотуудаас орох, гарах хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл түр хаагаад байгаа. Иймээс

Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид болон ажилтан албан хаагчид та бүхнийг мэргэжлийн байгууллагуудын ажилтан алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхийн зэрэгцээ батлагдаагүй зам, маршрутаар хөдөлгөөн үйлдэж

өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулахгүй байхыг Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас анхааруулж байна.

Цагдаагийн ахлах ахлагч М.АРИУН-ЭРДЭНЭ

Редакцын шууданд

Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Завхан аймгийн өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Улсын онцгой комиссын хуралдаанаас Улсын нөөцөөс 883 тонн өвсийг үнэгүй, 905 тонн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох шийдвэр гарсан. Уг өвс, тэжээлийг сумдад хүргэх ажлыг цэргийн

дүйцүүлэх алба хааж буй иргэдийг оролцуулан амжилттай зохион байгууллаа.

310 дугаар анги

Ангийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн 2020 оны 2 дугаар сарын хурлаар сарын тэргүүний цэргийн алба хаагч, ажилчин албан

хаагчдыг шалгарууллаа.

Энэ сард өмнө тавьсан зорилго, зорилтыг ханган биелүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж, цэргийн алба, сахилга, дэг журам, сургалт бэлтгэл, ажил үйлсээрээ манлайлсан Тэргүүний албаар захиргааны удирдлагын алба, сургалт, соёл хүмүүжлийн алба, Тэргүүний офицероор хуулийн зөвлөх, ахлах дэслэгч

Б.Мөнхбат, Тэргүүний ахлагчаар тээврийн батальоны ахлагч, ахлах ахлагч Ж.Нямхүү, Тэргүүний ажилтан албан хаагчаар тээврийн батальоны тусгай тээврийн ротын жолооч Ч.Бат-Эрдэнэ нар шалгарч ар гэрт нь талархлын захидлыг “Монгол шуудан” компаниар дамжуулан илгээлээ.

Ахлах дэслэгч Б.УРАНЧИМЭГ

“АЛТАН ГАРТ”-НУУДЫН АВЪЯАСЫГ ӨВЛӨНӨ

Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн нэгдсэн засварын хороо буюу Зэвсэгт хүчний 011 дүгээр ангиас “Шавь төвтэй сургалт”-ыг явуулж эхэллээ. Кранчин, түлшний аппаратур-форсунк засварчин, хөдөлгүүрийн засварчин, дуран-гэрэллэг хэрэгслийн засварчин, буудлагын зэвсгийн засварчин, чирэгчийн жолооч гэх зэрэг манай улсын Зэвсэгт хүчинд нэн хэрэгцээтэй мэргэжлийг 1975 оноос буюу тус ангийг байгуулагдсан цагаас хойш бэлтгэж эхэлжээ. Өдгөө тэдгээр “алтан гарт”-нуудаас хэдхэн нь тус ангид үлдсэн бөгөөд бүгд энэ жил гавьяаныхаа амралтад гарах ажээ. Тиймээс эдгээр чухал мэргэжилтэй хүмүүсийн залгамж халааг бэлтгэхийн тулд Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн удирдлагаас ийнхүү тус үйл ажиллагааг зохион байгуулсан юм. “Ангийн тайван цагийн орон тоо шинэчлэгдэж, улс орны бүтээн байгуулалтын ажилд манай бүрэлдэхүүн оролцох болсноор сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсон. Тус анги нь нэгдсэн засварын хороо учир ажиллаж байгаа офицер, ахлагч нарын ур чадвар маш сайн байх учиртай. Энэхүү шаардлагыг

хангахын тулд “Шавь төвтэй сургалт”-ыг хэрэгжүүлж байна. Тэтгэвэр, чөлөөндөө гарах болсон ахмадуудынхаа мэргэжлийн ур чадварыг өвлөн авч үлдэх асуудал бидэнд тулгараад байгаа учир уг сургалтыг зохион байгуулахаар шийдсэн юм. Суралцагчдаа сонгохдоо ч мөн өндөр шалгуур тавьж, дээрх чухал мэргэжлүүдээр суралцах чин хүсэл эрмэлзлийг нь чухалчилсан. Засварчин мэргэжил тухайн хүнээс олон жил мэргэшихийг шаарддаг онцлогтой. Өөрөөр хэлбэл нэг засварчин бэлтгэхэд доод тал нь 10 жил зарцуулагддаг гэсэн тооцоо бий” гэж тус ангийн захирагчийн орлогч-ахлах инженер, дэд хурандаа Г.Ариунболд хэлсэн. Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг хангахад тэдгээр ахмадуудын хийсэн болоод хийж байгаа үйлс хэмжээлшгүй их гэдгийг сурвалжлагч миний бие тэдэнтэй уулзсанаар ойлгосныг энд нуух юун.

Ингээд өөрсдийн олон жилийн нөр их хөдөлмөр, мэдлэг, туршлагаа шавь нартаа өвлүүлэхээр хөдөлмөрлөж байгаа “алтан гарт”-нуудын сэтгэгдлийг уншигч танаа болгоё.

ашиглалтын инженер мэргэжлээр төгссөнөөс хойш өнөөг хүртэл дизель хөдөлгүүрт машин механизмын аппаратур, форсунк, өндөр даралтын насосыг шалгаж, засварлах ажлыг гүйцэтгэж явна. Би Зэвсэгт хүчинд 40 гаруй жил ажиллаж байна. Миний аав Барилгын цэрэгт жолооч байсан бөгөөд анх 1978 онд Монголд “Камаз” орж ирэхэд нь жолоодож байсан юм. Тэр үеэс л авыгаа дагаж дизель хөдөлгүүртэй “ноцолдож” эхэлсэн. Мэргэжлээ гүнзгийрүүлээд хөдөлгүүрийн аппаратур, форсункыг дагнан



Шавь, дэд ахлагч Н.Отгонбаатарын хамт

ямар нэгэн юмны цаагуур орчихвол би юу ч харахгүй. Мөн тухайн ачааг зөв оосорлож, өргөхөд бэлэн болгосон эсэхийг ч харах боломжгүй. Тийм болохоор заавал мэргэжлийн оосорлогч-дохиочин байх шаардлагатай. Гэтэл үүнийг зарим цэргийн дарга нар ойлгодоггүй. Энэ талын мэргэжилтэнг албан ёсоор бэлтгэдэггүй. Энэ нь наанадаж эд хөрөнгийн хохирлоос цаашлаад эрдэнэт хүний амь настай холбоотой асуудал гэдгийг хамгийн түрүүнд ухамсарлах ёстой. Харин миний шавь намайг дагалдаж суралцсаар мэргэжлийн оосорлогч-дохиочны үнэмлэхтэй болсон. Манай Зэвсэгт хүчинд мэргэжлийн оосорлогч-дохиочин түүнээс өөр байхгүй.

Кранчин хүн хүний амь насыг эрсдэлд оруулахгүй байх, өргөж байгаа ачаагаа мэдрэх, орон зайгаа сайтар шалгаж, дараагийн үйлдлээ хийх гэсэн үндсэн чадваруудыг заавал эзэмшсэн байх ёстой. Ер нь орон зайн мэдрэмж сайтай байж кранчин болно. Насаараа суралцдаг нандин мэргэжил гэж боддог.

ЗЭВСЭГТ ХҮЧИНД ХОЁРХОН БАЙДАГ МЭРГЭЖИЛТНИЙ НЭГ НЬ БИ

Дуран, гэрэллэг багажийн засварчин, ахлагч Г.ҮҮРИЙНЦОЛМОН:

-Би Ахлагчийн сургуулийг зэвсгийн нярав мэргэжлээр 2009 онд төгсөөд тус ангид Х.Атар ахыгаа дагалдан дуран, гэрэллэг хэрэгслийн засварчнаар ажиллаж байна. Зэвсэгт хүчинд маш ховор байдаг мэргэжлийг эзэмшихээр суралцаж байгаадаа өөрийгөө азтай гэж боддог. Мөн өнөөдөр багшдаа хадаг барьж албан ёсны шавь нь болсондоо баяртай байна. Түүнчлэн өөрийгөө давхар хөгжүүлэх зорилгоор оройн цагаар ШУТИС-ийг токарчин мэргэжлээр төгссөн. Төгсөж ирээд лац зордог токарийн машин дээр ажиллаж, төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын захиалгыг гүйцэтгэж байна.

Х.Атар багш маань өөрийн мэддэг бүхий л зүйлээ надад зааж сургахыг хичээдэг. Манай дуран, гэрэллэг хэрэгслийн засварчин цех артиллерийн 36 төрлийн дуранг



Багш Х.Атарын хамт

тусгай багажуудаар засдаг. Дурангийн засвар нь хүний нүдний харааны чадвар, оптикын хуулийн нарийн мэдлэг шаарддаг.

САЙН ШАВЬ БЭЛДЭЖ ӨГНӨ

Зэвсгийн цехийн засварчин Ч.БОЛД-ЭРДЭНЭ:

-Зэвсэгт хүчний 015 дугаар ангид 1977-1980 онд хугацаат цэргийн алба хаасан. Тус ангид байхдаа зэвсгийн мастерын дамжаанд нэг жил суралцсан минь хожим намайг Зэвсэгт хүчинтэй 38 жил хувь заяагаа холбох их замын эхлэл байжээ. Би буг хүлээж аваад гэмтлийг нь тодорхойлж, засаж чадна, бүх бууны модыг нь өнгөлж, төмрийг нь харлуулж засаад, буцаагаад угсарч чадна.



Шавь, дэд ахлагч П.Мягмардоржийн хамт

“АК”, “АКМ” хоёр өөр эд ангиудтай. Гагцхүү тэр олон бууны эд ангиудыг өөр хооронд нь солихгүйгээр угсарч чаддаг байх ёстой. Намайг өдий зэрэгтэй чадварлаг мэргэжилтэн болоход миний хамт олон, цэргийн сайн дарга нар нөлөө үзүүлсэн. Дээр нь гурван жилийн хугацаат цэргийн алба намайг хүмүүжүүлж, захирах, захирагдах ёсонд сургасан. Өнөөдрийг хүртэл эх орондоо зүтгэсээр л явна. Манай дарга нар намайг шавь төрүүл, шавийг чинь харж байж таныг явуулна гэдэг юм. Би Зэвсэгт хүчиндээ сайн шавь бэлдэж өгөх болно. Манай засварчин цехийн зассан буунуудтай холбоотой ямар нэгэн гомдол ирж байгаагүй. Энэ бол бидний нөр их хөдөлмөрийн нотолгоо билээ.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

БҮХ БУУ МИНИЙ ГАРААР ДАМЖСАН

Зэвсгийн цехийн засварчин Ж.ЭНХБАТ:



Шавь, ахлагч Э.Эрдэмсүмбэрэл, Б.Мөнхбат нарын хамт

-Хугацаат цэргийн албанд татагдаад тус ангид ирж байлаа. Манай анги харуул, аж ахуй, үйлдвэрийн роттой байсан бөгөөд тэнд хуваарилагдсан мань мэтийн цэргүүд засварчин ахлагч нарын гарын үзүүрт зарагдаж, ажил хийж сурдаг байлаа. 1975 онд манай засварын үйлдвэр ашиглалтад орсон. Миний хувьд тракторчин мэргэжилтэй байсан учир танкийн засварчид дээр томилогдож, тэдэнд туслах ажил хийх дуртай байлаа. Хүүхэд байсан болохоор техниктэй харилцах ажил миний сонирхлыг их татсан. Гэвч цэргийн албанаас гачигдлаар хугацаанаасаа өмнө халагдсан учир Улсын нийтийн аж ахуйд тракторчнаар ажиллалаа. Гэсэн хэдий ч Зэвсэгт хүчний 011 дүгээр ангид ажиллаж, алба хааж байсан минь бодогдоод ер салдаггүй. Тэгээд авыгаа ангийн захирагчтай уулзуулснаар өөрийн хүсэлтээр энд ирж, цехийнхээ босгыг давж байсан нь 40 жилийн өмнө билээ. Дагалдан засварчнаар бүтэн хоёр жил ажиллаад жинхэллээ. Яг мэргэжлийн ном үзэж, сургуулийг нь төгсөөгүй ч тэр үеийн мундаг мэргэжилтнүүдээс бууны талаар их зүйлийг сурч, мэдэж авсан нь намайг өдий зэрэгтэй засварчин болгожээ.

Социалист нийгмийн үед төлөвлөгөө, норм биелүүлнэ гээд ЗХУ-аас ирж байгаа буунуудыг хэдэн зуугаар нь засварлан, туршиж, анги, байгууллагууд руу илгээдэг байлаа. Энд би нэг зүйлийг хэлж чадна. Учир нь бүхий л цэргийн алба хаагчдын гар дээр очсон буу миний гараар л дамжсан.

НАМАЙГ “АЛТАН ГАРТ АМАРАА” ГЭЖ

ХҮНДЭТГЭН ДУУДАГ

Хөдөлгүүрийн засварчин Б.АМАРБАЯР:



Шавь, дэд ахлагч М.Бат-Амгалан, Т.Пүрэвбаатар нарын хамт

-Тус ангид 1995 онд анх хөдөлгүүрийн засварчнаар ажилд орж байлаа. Залуухан ёстой л “галзуу барын аманд гараа хийхээс ч буцахгүй” байсан би Зэвсэгт хүчний 011 дүгээр ангиас их зүйл сурсан. Би 17 жил энэ ангитай хувь заяа холбон ажиллахдаа Зэвсэгт хүчний маш олон техникийн моторыг боож байлаа. Дорнод, Сүхбаатар, Баян-Өлгий, Баянхонгор гээд олон ч газар Зэвсэгт хүчний ангиудыг шинээр болон шилжин байрлуулах цуваанд багтаж, ард нь хоцорч эвдрэлтэй моторуудыг засаж, сэлбэж тостой холилдооор байгаад л буцаж ирдэг байлаа. Манай Зэвсэгт хүчнийхэн намайг “Алтан гарт Амараа ах” гэдгээр минь сайн танина. Одоо тэтгэвэртээ гарсан ч ангитайгаа үргэлж холбоотой байдаг. Намайг сурж, мотор боолгуулах гэсэн хүмүүс манайд их ирнэ. Тавантолгой, Гашуунсухайт гээд л энд тэнд том, том уурхайд очиж, “Норд бенз, “Хово” зэрэг орчин үеийн ачааны тэрэгний моторыг ч түвэггүй боочихно. Залуус хэлдэг л юм, “Та ийм хөгшин байж, яаж ийм том моторыг ганцаараа боож чаддаг байна аа” гэж. Би тэгэхэд нь “Арми намайг ингэж хүмүүжүүлсэн юм. Ахынх нь өдий зэрэгтэй хөдөлмөрлөж чадаж байгаа нь Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн “алтан гарт”-нуудаас сурсан мэдлэг, чадварын гавьяа” гэж хэлэх дуртай.

Хэдий би завгүй байдаг ч ангидаа заавал өөрийн гэсэн хувь нэмрийг оруулах ёстой гэж бодсон бөгөөд залуу дүү нартаа өөрийн чаддаг, мэддэг бүхнээ харамгүй заахаар ирээд байна. Заавал сайн шавь төрүүлэх болно.

ДИЗЕЛЬ ХӨДӨЛГҮҮРИЙН ЗҮРХ НЬ

АППАРАТУР

Аппаратур, форсункын засварчин

П.ХҮРЭЛБААТАР:

-ЦНДС-д 1980-1984 онд суралцаж хуягт танкийн

засварлаж байна.

Өнөөдөр олон улсын армиуд тэр чигээрээ дизель хөдөлгүүрийг түлхүү хэрэглэж байна. Учир нь бензин хөдөлгүүрийг бодвол дизель хөдөлгүүр нь түлш зарцуулалт бага, хүчин чадлаараа илүү зэрэг олон давуу талтай. Муу моторыг сайн аппаратур авч явдаг, дизель хөдөлгүүрийн зурх нь аппаратур юм. Манай оронд импортлогдож байгаа түлшний чанар муу болохоор цэргийн зориулалттай ч гэлтгүй бүх тээврийн хэрэгслүүдийн аппаратур, форсунк



Шавь, дэд ахлагч Г.Бямбасүрэнгийн хамт

нь амархан доголдог. Тийм учраас миний мэргэжил дан Зэвсэгт хүчин ч гэлтгүй автомашин унаж, хэрэглэж байгаа газар бүхэнд маш чухал. Ийм л мэргэжлийг хоёр дүүдээ өвлүүлэхээр өнөөдөр албан ёсоор багш нь боллоо. Багш хүний хариуцлагыг ухамсарлаж, дараагийн үеэ чанартай бэлтгэхийн тулд хичээх болно.

АЛЬ Ч ТЕХНИКИЙГ ГОЛЖ БОЛОХГҮЙ

Автотээврийн салааны жолооч,

бэлтгэл сургагч ахлагч Д.БАТДОРЖ:



Шавь, ахлагч В.Энхбаярын хамт

-Би 1982 онд тус ангид хугацаат цэргийн албанд ирэхдээ “Маз-537-Г” маркийн машин дээр хэрхэн ажиллаж, ашиглах талаар орос мэргэжилтнээр заалгаж байлаа. Тэр цагаас хойш энэ машинтайгаа хоёргүй сэтгэлээр зүтгэсээр өнөөдрийг хүрчээ. Авто тээврийн салааны механик жолооч, авто тээврийн салааны захирагч хийж байгаад 2013 онд тэтгэвэрт гарсан ч ангидаа энгийнээр өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Энэ хугацаанд “УАЗ-469”, “Газ-66”, “Зил-130”, “Зил-131”, “МАЗ-537-Г”, “МЗГКТ” гэх мэт Зэвсэгт хүчний бүхий л авто техникийг барьж байлаа. Зэвсэгт хүчнийхээ төлөө олон ч аймаг, сум руу хуягт танкийн болоод бусад техник, хэрэгслүүдийг ачиж, чирч аюулгүй хүргэж өгч байсан. Миний хамгийн хайртай, надтай хамт энэ ангид “алба” хааж байгаа “Маз-537-Г” чирэгч нь хүнд даацын техник бөгөөд үндсэн бие нь 22 тонн, чиргүүл нь 12 тонн юм. Тэгээд 70 гаруй тонн ачаа ачихаар 100 гаруй тонн хүнд “төмөр”-ийг хөдөлгөнө гэсэн үг. Ер нь зуны улиралд ачаа тээвэрлэхэд илүү хүнд байдаг. Учир нь техникийн масс хүнд учир зөөлөн хөрсөнд шигдэх, шаварт суух асуудалтай элбэг тулгарна. Тухайн үед чинь тийм хүнд “төмөр”-ийг шавраас чирээд гаргачих техник байхгүй. Тэгээд л жолооч хүний ур ухаан сийлнэ шүү дээ.

Би орос мэргэжилтнүүдээс ажилдаа чин сэтгэлээсээ хандах чанарыг нь хамгийн түрүүнд сурч авсан. Аль ч техникийг голж болохгүй. Гагцхүү түүнийг ажиллуулж байгаа хүн нь чадварлаг байх ёстой. Би ийм л зүйлийг шавь нартаа хэлж өгдөг.

НАСААРАА СУРАЛЦДАГ НАНДИН МЭРГЭЖИЛ

Инженерийн засварын цехийн гинжит механикийн засварын тасгийн дарга, ахлах ахлагч Д.САНСАР:

-ЦИС-ийг хуягт танкийн дадлагын багш, механик жолоочоор 1993 онд төгссөн. Би Зэвсэгт хүчинд 27 дахь жилдээ алба хааж байна. Тэтгэвэрт гарах хугацаа ч дөхсөн. Тийм болохоор гарын шавиа бэлдэж, өөрийнхөө залгамж халааг үргэлжлүүлэхээр ажиллаж байгаадаа баяртай байна. Хүн мэргэжлийг голох ёсгүй, харин мэргэжил хүнийг голдог. Миний зааж, сургах мэргэжил бол кранчин. Ер нь бол кранчин оосорлогч-дохиочинтойгоо хамт ажиллах ёстой. Кранчи сум барилгын ч юм уу эсвэл

Зэвсэгт хүчний 99 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан Монголын энхийг сахиулагчдын талаарх гаднын улсын сэтгүүлчдийн бичсэн нийтлэл, мэдээг орчуулан хүргэж байна.

МОНГОЛЧУУД АФРИКТ ХЭРХЭН ЭНХИЙГ САХИУЛЖ БАЙНА ВЭ?

Энхийг сахиулагчдад зориулан орон нутгийг нь амар тайван болгож, сургуулийг нь засварлаж өгсөнд талархсанаа илэрхийлж хэдэн арван сурагч сургуулийнхаа нэгэн ангид цугларч, дуулан бүжиглэнэ. Сурагчид болон цэнхэр дуулгатууд сэтгэл хангалуун байгаа нь тэдний харцнаас илхэн

нэрлэгдэх хэмжээнд хүрсэн. Энэ ч утгаараа 1990 оны сүүлчээр Зэвсэгт хүчин нь шинэ нийгмийн давуу талыг соргоогоор мэдэрч, энхийг сахиулах олон улсын цэргийн ажиллагааны талбарт өөрийн оролцоог нэмэгдүүлсэн юм. Ялангуяа бүс нутагтаа ардчиллын үнэт зүйлсийг хамгаалагч орон гэдгээ дэлхий

цэргийн алба хаагчдынх нь 13,7 хувь нь хилийн чанадад үүрэг гүйцэтгэсэн гэсэн судалгаа тус онд гарсан. 2003 оноос хойш Монгол Улсын Зэвсэгт хүчнээс давхардсан тоогоор 14000 гаруй цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон байна.

НҮБ-аас сүүлийн жилүүдэд Жендэрийн тэгш эрхийг хангах



харагдана. Энэ өдрийн хамгийн сайхан хэсэг нь сурагч охидын хувьд эмэгтэй энхийг сахиулагчдаас урам зориг авч ирээдүйд тэдэн шиг энх тайван нийгмийн төлөө тэмцдэг эрэлхэг бүсгүйчүүд болох мөрөөдөлд умбана. Харин тэд иргэний дайнтай нийгэмд энхийг сахиулагчид хэрхэн эерэг хандлага авчирч, энх тайвныг тогтоож болдгийг харуулсан зурагт хуудсуудыг тэдэнд үзүүлнэ. Энэхүү дүр зургийг харсан надад үнэхээр БНӨСҮ-д эргээд энх цаг ирж байгаа гэж бодогдсон юм. Тэдэнд гэрэл гэгээ бэлэглэж байгаа тэдгээр энхийг сахиулагчид Монгол Улсаас ирсэн байлаа.

Монгол Улс нь далайд гарцгүй дэлхийн хоёр дахь том улс бөгөөд төв Азид оршдог юм. Тус улсаас 900 гаруй цэргийн алба хаагч БНӨСҮ-д үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд Париаг суурингийн дунд сургуульд 50,000 ам.долларын өртгөөр сэргээн засварлах ажлыг гүйцэтгэж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлжээ. Мөн тэд сургуулийн хуучирч муудсан ханыг шинэ мэт болгоод гайхалтай зураг зурсан байв. Тэрхүү ханан дээр Монголын ногоон зүлэгтэй өргөн уудам тал нутаг, толгодыг дүрсэлсэн нь Африкийн хөдөө тал шиг уудам сэтгэгдэл төрүүлэх мэт.

Монгол Улсын Зэвсэгт хүчинд 1990 оноос өмнө ЗХУ-ын нөлөө их байсан бөгөөд зэвсэглэл, техникүүд нь ч мөн тэр үеийнх. Хүн ам нь гурван сая гаруй бөгөөд дэлхийн хоёр том гүрэн болох ОХУ, БНХАУ-ын дунд оршдог ч тус улс нь эдүгээ олон улсын энхийг сахиулах ажиллагааны гол тоглогч болжээ, ялангуяа Африк тивд. Өнөөдөр Монгол Улс нь төв Азийн орнуудаас ардчиллыг үлгэр жишээ хөгжүүлэгч орноор зүй ёсоор

нийтэд харуулж, 2003 онд "Иракийн эрх чөлөө" ажиллагаанаас эхлэн цэргийн алба хаагчид нь олон улсад мэргэжлийн чадвараараа танигдсан. Ер нь монгол цэргүүд аль ч улсад үүрэг гүйцэтгэсэн мэргэжлийн ур чадвар, сахилга бат, тэсвэр хатуужлаараа бусад улсын цэргээс ялгарч ирсэн гэдгийг тэдэнтэй хамт үүрэг гүйцэтгэж байсан бусад орны цэргүүд хэлдэг.

Тэд шилдэг энхийг сахиулагчдаа НҮБ-ын болон олон улсын цэргийн ажиллагаанд илгээхээс гадна бүс нутагтаа жишиг болохуйц хамгийн том энхийг дэмжих ажиллагааны хэргийн сургууль "Хааны эрэлд"-ийг АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлалтай хамтран жил бүр зохион байгуулсаар ирсэн. Энэ талаар би 2017 онд Балба улсад зохион байгуулагдсан энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургуулийг сурвалжилж байхдаа дэд хурандаа Д.Мягмаржаваас тодруулсан юм. Тэр бээр хэлэхдээ "Бид НҮБ-ын гишүүн орны хувьд даян дэлхийн энх тайвны төлөө өөрсдийн хувь нэмрийг оруулахыг хичээдэг. Монгол цэргүүдийн хөгжилд энхийг сахиулах ажиллагаа чухал нөлөө үзүүлсээр ирсэн. Энэ ч утгаараа өнөөдөр бид "дэлхийн цэрэг" болж хөгжсөн" гэв.

Монгол Улс нь бусад энхийг сахиулагчдаа илгээдэг орнуудыг бодвол хүн ам цөөн ч нэг хүнд оногдох энхийг сахиулагчдынхаа тоогоор тэргүүлдэг юм. Мөн нийт цэргийн алба хаагчдынхаа дунд цэнхэр дуулгатуудын эзлэх хувиараа ч бусад орнуудыг манлайлдаг. 2017 онд тус улсаас 1100 гаруй цэрэг энхийг сахиулсан нь түүхэнд байгаагүй амжилт байсан бөгөөд нийт

зорилгоор эмэгтэй энхийг сахиулагчдын тоог нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Эл бодлогыг эрчимтэй дэмждэг орнуудын тоонд Монгол Улс зүй ёсоор тооцогдоно. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын БНӨСҮ дахь суурин төлөөлөгч Дэвид Шийрэр Монголын энхийг сахиулагчдад НҮБ-ын медаль гардуулах ёслолын үеэр "Монголчуудын үүрэг гүйцэтгэлтний талаар би их дуулсан. Үнэхээр анх сонсож байгаа хүнд "Үнэн үү?" гэж ахин дахин асуумаар тийм л чадварлаг, маш үр дүнтэйгээр энхийг сахиулж чадаж байгаа нь гайхалтай. Ялангуяа танай эмэгтэй цэргийн алба хаагчид хариуцлагын бүсдээ энх тайван байдлыг авчрахад жинтэй хувь нэмэр оруулж байдаг би гүнээ талархаж байна. БНӨСҮ-д тулгараад байгаа нөхцөл байдлыг арилгахад та бүхний хичээл зүтгэл бидэнд ус, агаар мэт хэрэгтэй байна" гэж хэлсэн юм.

2018 оны байдлаар 116 улс НҮБ-д цэрэг илгээж байна. Тэднээс 36 улс нь ямар нэгэн эмэгтэй цэргийн алба хаагчдыг илгээдэггүй. Харин 46 улс нь дөнгөж 0,1 хувийг эзлэх эмэгтэйчүүдийг илгээдэг бол 32 улс нь энхийг сахиулагчдынхаа 15-аас дээш хувийг нь эмэгтэйчүүдээр бүрдүүлдэг байна. Одоогийн байдлаар Монгол Улсын энхийг сахиулагчдаас ажиглагч болон холбогч офицеруудын 27,3 хувийг, штабын офицеруудын болон батальоны бүрэлдэхүүний 10 хувийг эмэгтэй цэргийн алба хаагчид эзэлж байна.

ЖЕРЕМИ ЛУЕДИ

2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр "www.asiabyafrica.com" цахим хуудсанд нийтэлжээ.

ОРОН НУТАГТ ХӨДӨЛГӨӨНТ ЭМНЭЛГИЙН БАГ АЖИЛЛАЖЭЭ



Ангелина Чол олон жилийн туршид арьсны өвчнөөс болж шаналж байв. Тэр бээр 2017 онд Бентью хотын дүрвэгсдийн хуарангаас Куорбони тосгоныг зорьсон ч, тэндээ очоод өвчин тусаж, эрүүл мэндийн тусламж авч чадахгүй байсаар онош нь хүндэрч, олон жил шаналжээ. Гэтэл нэгэн сайхан завшаан түүнд тохиолдсон нь "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын энхийг сахиулагчид орон нутгийг хамарсан хөдөлгөөнт эмнэлгийн үзэл явуулж Ангелина Чолыг эмчилжээ. Тэр бээр 32 настай бөгөөд түүнтэй хамт 300 гаруй өвчтөнүүд тус үзлэгт хамрагдсан байна. "Бид энэ тухай мэдээллийг сонссон даруйдаа очиж үзүүлсэн. НҮБ-ын цэргүүд ирж биднийг эмчилсэн нь амьдралд үнэхээр их тус боллоо. Би баяртай байна" гэж Ангелина Чол хэлэв.

БНӨСҮ-ын Куорбони, Манга тосгонд ямар ч эмнэлэг, сургууль, тэр ч бүү хэл цэвэр усны хангамж байдаггүй. Тийм учир оршин суугчид нь тосгоноосоо ихээр явж байгаа ажээ. Монгол Улсын энхийг сахиулагчид өөрсдийн хариуцлагын бүс дэх орон нутгийн иргэдэд эмнэлгийн тусламжийг хөдөлгөөнт байдлаар үзүүлснээс гадна хэрхэн гараа зөв угаах, ариун цэвэр сахиж, халдварт өвчнөөс өөрийгөө болон бусдыгаа хамгаалах тухайд хичээл зааж, анхны мэдэгдэхүүнтэй болгосон нь НҮБ-ын цэргийн нэр

хүндийг орон нутагт сурталчлан таниулсан үр дүнтэй үйл ажиллагаа болсон.

Мөн Париаг сууринд байрладаг Монголын энхийг сахиулагчдын рот тус бүс нутагт оршин суудаг 400 гаруй хүнд эмнэлгийн тусламжийг үзүүлсэн байна. Тэдний нэг Париаг суурингийн оршин суугч Биел Ём Дэнг хэлэхдээ "Надад энхийг сахиулагчдад хандан баярлалаа гэж хэлэхээс өөр хэлэх үг олдохгүй байна. Тэднийг бурхан ивээг. Миний хүүхдүүд болон эхнэр өвчин тусаж, манай гэр бүл хүнд байдалд ороод байсан. Гэтэл та харж байгаа биз дээ, бид одоо эрүүл болсон байна шүү дээ. Энэ бол энхийг сахиулагчдын гавьяа" гэж сэтгэгдлээ хуваалцсан.

Мөн оршин суугч Риа Гатгек "Манай улсын эрх баригчид ард түмэндээ учраад байгаа энэхүү хүнд бэрх цаг үеийг ойлгож, энх цагийг авчирна гэдэгт итгэж байна. Хэрвээ манай улсад энх тайван тогтвол эмнэлэг, сургууль, цэвэр усны байгууламжууд дахин шинээр баригдаж, бид дахин зовохгүй" гэж бидэнд хэлсэн юм. Оршин суугчид энэ мэт энхийг сахиулагчдын үүрэг гүйцэтгэлтэд сэтгэл хангалуун байна.

ЛУК РИЕК НУЯК

2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр "www.unmiss.unmission.org" цахим хуудсанд нийтэлсэн.

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ДҮРВЭГСДИЙН АМЬ НАСЫГ АВАРЛАА



Монголын энхийг сахиулагчид 2017 оны 2 дугаар сарын 22-ны орой дотооддоо дүрвэгч иргэдийн амь насыг Суданы Ардын Чөлөөлөх армийнхны гараас аварчээ. БНӨСҮ дахь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын төлөөлөгч Дэвид Шийрэр уг болсон явдлын талаар "Энхийг сахиулагчдын явуулсан шуурхай арга хэмжээг үнэлж байна. Монгол цэргүүдийн эр зориг маш их юм. Тэд Дотоодын дүрвэгсдийн хуарангийн аюулгүй байдлыг үргэлж найдвартай хамгаалж байдаг талархаж байна" гэж сэтгэгдлээ илэрхийлэв.

Болсон цагийн байдлын мэдээгээр Лхагва гарагийн шөнө Суданы Ардын Чөлөөлөх Армийн хэд хэдэн цэргүүд Бентью хотын ойролцоох тосгоны хажууд явж байсан 11 дүрвэгчийн биед халдаж, хүчирхийлэхийг

оролджээ. Энэ байдлыг ажигласан Монгол Улсын энхийг сахиулагчид шуурхай арга хэмжээ авч, долоон эмэгтэй, дөрвөн эрэгтэйг аварч, амь насыг нь хамгаалжээ.

Бентью хотын ойролцоох газруудад энэ мэт олон тохиолдол гардаг ч монгол цэргүүд шиг шуурхай арга хэмжээ авч ажиллаж чадах нь ховор байдаг юм. Одоогийн байдлаар Юнити мужид Дотоодын дүрвэгсдийн хуаран нь хамгийн аюулгүй газарт тооцогдож байгаа учир хүмүүс олноороо дүрвэн тус хуаранд орогнох болсон. Бентьюд байрлах тус хуаран нь БНӨСҮ-даа хамгийн томд тооцогддог бөгөөд 120,000 дүрвэгч байрладаг юм.

ДАНИЕЛ ДИКИНСЕН
2017 оны 2 дугаар сарын 27-ны өдөр "www.reliefweb.int" цахим хуудсанд нийтэлсэн байна.

ЛИЙР ТОСГОНД ЭНХИЙГ САХИУЛАВ



БНӨСҮ-д явагдаж байгаа "UNMISS" ажиллагаанд Монголын цэнхэр дуулгатууд маш үр дүнтэй үүрэг гүйцэтгэж байна. Тэд тус улсын цагийн байдлын хамгийн хүнд бүс нутагт буюу Юнити мужид энхийг сахиулдаг юм. БНӨСҮ-д өрнөж байгаа иргэний дайны галд тус мужийн Лийр тосгоны иргэд маш ихээр өртөж байв. Сөргөлдөгч хоёр талын байлдааны ажиллагаа тус мужид ширүүн явагдаж байсны улмаас иргэд олноороо дайнд амь эрсдэж эхэлсэн. Иймд UNMISS ажиллагааны хүчний командлагч 2015 онд БНӨСҮ-ын цагийн байдлын хамгийн халуун цэгт Монгол Улсын

энхийг сахиулагчдыг илгээх шийдвэр гаргасан юм.

Тэд ч энэхүү хүнд даалгаврыг хүлээж авсан даруйдаа туршуулын бүлгийг тус тосгон руу илгээж, сар хүрэхгүй хугацаанд баазаа байгуулж чадсан. Засгийн газрын болон Засгийн газрын эсрэг хүчний байлдааны ажиллагааны дундуур энхийг сахиулагчид орж байрласан нь "UNMISS" ажиллагаанд ч бус бусад явагдаж байгаа НҮБ-ын цэргийн ажиллагааны түүхэнд содон үйл явдал болсон байна.

Лийр тосгонд үйл ажиллагаа явуулдаг "Норвегийн дүрвэгсдийн холбоо"-ны мэргэжилтэн Нора

Сандерс хэлэхдээ "БНӨСҮ-д явуулж байгаа манай хүмүүнлэгийн үйл ажиллагаанд Лийр тосгонд байрлах Засгийн газрын эсрэг хүчнийхэн байнга саад хийдэг байсан. Гэтэл нэгэн өдөр "UN" гэсэн бичигтэй цагаан хуягт тээвэрлэгч хөлөглөсөн энхийг сахиулагчид тус тосгонд орж ирсэн. Орон нутгийн иргэдээс эхлээд сөргөлдөгч хоёр тал, миний бие ч гэсэн эл үйл явдлыг хараад үнэхээр гайхсан. Тэд шууд өөрсдийнхөө баазыг сөргөлдөгч хоёр талын дунд байгуулсан. Хэдэн өдөртөө энхийг сахиулагчдын баазын дээгүүр талуудын байлдаан үргэлжилж, тэдний толгой дээгүүр сум шунгинаж байлаа. Харин энхийг сахиулагчдын уйгагүй хөдөлмөр, эр зоригийн ачаар удалгүй байлдааны гал зогссон. Одоо эндхийн хүмүүс амар амгалан байх болж, бид хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаагаа айл айдасгүй явуулах болсон. Монгол цэргүүдийн эр зоригийг би үнэхээр биширч байна" гэсэн юм.

Өнөөдрийн байдлаар хариуцлагын бүс нутагтаа НҮБ-ын цэргийн цуваатай эргүүлийг хамгийн их хийж байгаа цэргийн баг нь Монгол Улсын батальон юм. Тэд БНӨСҮ-д энх цагийг авчирч байна.

ДАНИЕЛ ДИКИНСЕН
2016 оны 3 дугаар сарын 5-ны өдөр "www.unmultimedia.com" цахим хуудсанд нийтэлжээ.

Хувьсгалт тэмцэлийн ахмад зүтгэлтэн, 1939, 1945 оны дайнд оролцогч, дэд хурандаа Балдангийн ДЭМЧИГ

Балдангийн Дэмчиг 1917 онд Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нутагт төрсөн. 1938 онд цэрэгт татагдан Тамсагийн 6 дугаар морьт дивизийн 15 дугаар морьт хороонд хуваарилагдан цэргийн албаны замаа эхэлсэн нэгэн. Бага наснаасаа хал үзэж, мод түлээ хийж, үхэр тэрэг, тэмээн хөсгөөр аянд явж хашир суусан түүнд цэргийн алба тийм ч хэцүү байсангүй. Цэргийн эрдэмд шамдан суралцаж байтал зүүн хязгаарт дайн эхэлж юу сурч, юу чаддагаа эх орон, ард түмэн, цэрэг, дарга нартаа үзүүлэх цаг болжээ

1939 он гарч Монгол Улсын зүүн хязгаарт Япон, Манжийн түрэмгийлэгчдийн зүгээс улсын хил зөрчих нь улам идэвхжин ширүүсэж, аюул занал илэрч болсон учраас Бүх цэргийн жанжны 6 дугаар морьт дивизээс нэг суманг Сүмбэрийн

гаргаж байна уу гэдгийг тодорхой баримтаар нотлох хэрэгтэй байна. Эс бөгөөс дивиз, хороодыг Халхын гол руу ирүүлбэл манайх дайн өдөөсөн болно гэж болгоомжилж байгаа учир манай руу чиглүүлж бэлтгэж байгаа хүчийг бүрэн мэдэхийн тулд хүчтэй тагнуулыг дайсны ар талд нэвтрүүлэх, ямар техник, зэвсэглэлтэй хүчийг хаана хуралдуулж, хэдийд, хаагуур довтлох гэж байгааг тодорхой харуулсан мэдээ олж ирсний дараа анги, нэгтгэлүүд болон Зөвлөлтийн Улаан армийн тусламжийг ирүүлэх болно. Дайсны ар тал, гүнд нэг салаа оруулж тагна” гэжээ. Дарга нар Шигшмэл сумангийн Б.Очир даргатай салааг томилохоор шийдвэрлэжээ. Салааны дарга Б.Очир “Морьдоо сайн тэжээ, буу

Шигшмэл сумангийн Б.Очир даргатай салаа тусгай үүрэг гүйцэтгэсэн дөрвөн сарын хугацаанд харуул, постод 40 удаа томилогдон, хил зөрчсөн дайсантай 13 удаа тулгаран байлдаж ялсан. Хэд дахин давуу хүчтэй дайсантай хоёр удаа тулалдан бүслэгдэж байсан боловч бага хохиролтойгоор гарч байжээ. Хил зөрчсөн дайсны амьд хэлийг барьж, зэр зэвсэг, эд зүйлийг нь олзолж байсны дотор дайсны тагнуулын сумангийн цоохор морьтой даргыг цэргүүдээс нь таслан хөөж барих үүргийг салааны дарга Б.Очир буурал морьтойгоо гүйцэтгэж дайчин олныг шагшруулж байсан гэдэг. Тэр даргын нууц баримт бичигтэй цүнхэнд чухал мэдээллүүд байжээ. Шигшмэл сумангийн



ЦАГААН УЛСЫН “ХҮРЭН БҮРТЭЭД”

заставт хүч нэмэгдүүлэх тушаал ирснээр дивизийн дарга морин хороодоос байлдааны бэлтгэл, сахилга, сурлагаар шалгарсан, нам, эвлэлийн гишүүн, шилдэг дарга, цэргүүдээр нэгэн суманг бүрдүүлж “Шигшмэл суман” хэмээн нэрлэв. Сумангийн даргаар Дорнод аймгийн Буйр сумын харьяат, Зүүн хил орчмын газар орныг сайн мэдэх Дашийн Шаравыг, улс төрийн удирдагчаар Данзангийн Махцэндийг /Завхан аймаг Нөмрөг сумын харьяат/, салааны дарга нараар Бизьяагийн Очир /Булган аймаг/, Доржийн Лувсанжамбаа /Архангай/, Чойдогийн Батаа /Сэлэнгэ аймаг/, Б.Очирын салааны туслах, тасгийн даргаар Балдангийн Дэмчиг, Дэмбэрэлийн Баасанхүү /Өвөрхангай аймаг/, Лувсанжамбаагийн салаанд Доржийн Гомбо /Ховд аймаг/, Шагдарын Ерэнтэй /Завхан аймгийн Отгон сум/, Батаагийн салаанд Д.Цэрэндорж /Дорноговь аймаг/ нарын зэрэг шилдэг дарга нарыг томилжээ. Шигшмэл суман 1939 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр гэхэд марш үйлдэх бүх бэлтгэлийг хангаж, 13-ны өдрийн өглөө 6 дугаар морьт дивизийн дарга, штаб, хороодын дарга нар нь Тамсагийн зүүн талд орших Тэчилэнгийн Балгасаас үдсэн бөгөөд 15-ны үүрээр Сүмбэрийн заставт иржээ.

Эхний хоёр өдөр газар орны байдал, хил зөрчсөн гол чиглэл, дайсны цэргийн дайнд бэлтгэж, байрлаж байж магадгүй байрлал зэргийг заставын дарга нараар заалгажээ. 1938 оны сүүлчээр хил давж ирсэн барга айлуудын хагас нь хилийн шугамаас гараагүй байсан үе. Заставын дарга П.Чогдон Шигшмэл сумангийн тасаг бүрд олон удаа харуулд гарсан дадлагатай хуучин цэрэг нэгийг өгч, харуул, постын зааг, харах цель, байрлалд бага зэрэг өөрчлөлт оруулан хүн, хүчээ тохируулан харуул, манаануудын хоорондын зайг ойртуулж нягтруулсан. 19-ний өдрөөс харуул манааны үүрэг гүйцэтгэж эхэлснээс гадна хилийн дотор байгаа айлуудыг гаргах ажлыг дарга, бага дарга нар гүйцэтгэжээ. Тэдний дунд салааны дарга Б.Очирын хамт Б.Дэмчиг явж, тэд хоёр хоногийн дотор үүргээ биелүүлэн айлуудыг гаргасан нь их урам өгсөн байна. Тэр айлуудын дотор Ар монголд элэгтэй сайн хүмүүс байсан ба хожим тагнуулын үүрэг гүйцэтгэхэд их тус болжээ.

Шигшмэл суман Халхын голын цаана Эмээл болон Талын манхан, Ганц модны элсэн бөөрөг, Гэр толгой, Хулд уулын чиглэлийг хариуцан шөнө бүр таван харуул, 10 пост гарган, морин холбоочид, паторул сэргийлэх шаардлагатай бол салаа, тасгаараа тагнуулд гаргаж байжээ. Хилийн дотор байсан айлуудыг гаргаснаас хойш 10-аад хоног тайван байж байгаад 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн өдөр болгон 2-3 онгоц агаарын хил зөрчин хилийн гүнд эргэлдэж, ганц морьтой цэрэг явсан ч онгоцоор хөөж, пулемётээр шүрших болов. Манай тагнуулчид хилийн чанад дахь цэргийн бүлэглэл улам нэмэгдэж, Баргын халуун рашааны хилийн орчимд ихээхэн цэргийн хүч хуралдуулан манай хил рүү тавьсан төмөр замаар өдөр, шөнөгүй ачаа тээж, аль нууц газруудад цэргийн байр, агуулахууд барьж, морин ба явган цэргүүд, машин техник, хуягт, их бууны ангиуд ирж, сургууль бэлтгэл хийж байгаа талаар мэдээг ирүүлж байлаа. Дайсны довтолгоо улам ширүүсэж, хил рүү Баргын хэд хэдэн сумантай морин хороо нэвтрэн харуул, постуудтай өдөр, шөнөгүй буудалцаж, техникийн ангиуд нь хилд тулж ирээд өдөөн үймүүлж, агаарын довтолгоо нь хилийн гүнд нэвтрэн Тамсагуулаар, Баянтүмэнг бөмбөгдөж эхэлжээ.

Цагийн байдал хурцадсан энэ үед Бүх цэргийн жанжны орлогч, Цэргийн явдлын яамны сайд, корпус командлагч Цэрэнжавын Лувсандоной Баянбүрдийн отрядад очин застав болон Шигшмэл сумангийн дарга нарыг дуудаж, Японы цэрэг манай хилийг зөрчиж, байлдаан өдөөж байгаа тухай илтгэл сонсоод, үүрэг өгч, тушаал буулгажээ. Тэрээр “... Одоогийн байдлаар япончууд манай эх орныг эзлэн түрэмгийлэхээр довтолж байна уу, зүгээр нэг хилийн будилаан

зэвсгээ арч, эмээл тохом, олом жирэм, хазаар дөрөөгөө шалгаж, чимээ гарах төмөр дөрөө, хазаарыг даавуугаар ороо, тасгийн дарга Дэмчиг, Баасанхүү, Дорж нарт цэргүүдээ бэлтгэ, онц сонор сэрэмжтэй бай, цэрэг нэг бүртэй ажилла” гэсэн үүрэг өгсөн байна. Цэрэг, морьдоо амраагаад 26-ны өдрийн орой бүрий болж байхад морьдоо эмээллэн хоёр богондоо хүн, морь нэг өдөр өл залгах хуурай хүнс, өвстэй морджээ. Халхын голыг гарч Хулд уулыг чиглэн довтолгож, замд тохиолдох өөрийн харуултай пароль солилцоод хилийн дагуу дайсны харуулын зайг урьдчилан тагнан төлөвлөснөөр нэвтэрчээ. Салаагаа тус бүр таван хүнтэй зургаан хэсэгт хувааж, ахлагч нарыг томилон үүрэг өгч, өглөөний 04.00 цагт уулзаж газраа товлоод явуулжээ. Салааны дарга Б.Очир морин жолооч Ц.Дандгай, бага дарга Б.Дэмчиг нарын хамт гурвуул үлдэж, нэг цаг хэртэй байдлыг ажиглаж байгаад Хулд уулын баруун хажууд ноход нь хуцаж байгаа айлуудад очьё гээд морджээ. Ойртоод очиход намхан уулын хажуугийн нөмөр хонхорт гурван гэр байжээ. Арав гаруй үхэртэй, хотондоо овоо хэдэн хоньтой байв. Үхрүүд дотор тэдний хөөж гаргахад танилцсан айлуудын халзан тарлангууд мөн байсныг Б.Дэмчиг таньжээ. Тэрээр “Хар нохой нь хүртэл биднийг таньж байна. Би жаахан идэх яс өгчихлөө одоо хуцахгүй, та хоёр морьдоо бариад нэг нь үхрүүд дотор, нэг нь тэр ойрхон хураасан түлшний хажууд бай” гээд явлаа. Гурван гэрийн баруун урдхад нь ороод хэсэг байсны дараа нэг хүний хамт гарч ирээд шууд түлшин дээр ирэв. Тэр хүн бэлтгэл цэрэг бололтой, удахгүй татагдах юм ярьж, цэрэгт очоод хэрхэн харьцах журмаа тогтов бололтой. Мөн Японы цэргийн хүч нэмэгдэж байгаа талаар болон төмөр замаар ямар ачаа хаана ирж байгаа зэрэг тодорхой мэдээ өгөөд дараачийн үүргээ авав. Энэ бол манай дарга нар дайсны дотор өөрийн найдвартай төлөөлөлтэй байж мэдээ авч байсныг гэрчилж байна. Тэд цуглах газраа ирж морьдоо идүүлж хүлээв. Т.Бэх-Очир ахлагчтай хэсгээс бусад нь цагтаа ирлээ. Дор бүрнээ л чухал мэдээтэй байв. Нөгөө хэсэг нь 05.00 цаг болж байхад ирлээ. Тохирсон ёсоор бол үүрийн гэгээ орохоос өмнө хил давах байсан боловч нэгэнт ийм болсон хойно үүрийн гэгээтэй уралдан давхисан ч талын элсэн манханд хүрч амжсангүй. Тэднийг дайсны харуулууд мэдээд манай салаанаас гурав дахин илүү 100 гаруй хүнтэй баргын морин суман талын манханд угтан бүслэжээ.

Элсний захад оруугаа морьдоо далдлан хориглож буудалцаж байтал дайсан дайрч эхлэв. Очир дарга “Пулемётын галын дор дайсны бүслэлтийг сэтлэн гарна, цэргүүд мориндоо, сэлмээ атаканд” гэж командлав. Салаа ч дайсны цэргүүдтэй дөрөө шүргэн цавчилдсаар бүслэлтийг нэвтэрлээ. Салааны сүүлчийн хүн гарч ирэнгүүт эргэж хориглон хүнээ бүртгэтэл пулемётын наводчик Батын Дашноров, туслах наводчик Пүрэвийн Бэх-Очир нар даргын тушаалыг биелүүлж, ширүүн галаар дайсны бүслэлтийг таслан нөхдөө гаргаад мориндоо мордож бүслэлтээс гарахаар дайрсан боловч морьдыг нь шархдуулсан тул сүүлчийн сумаа өөрсдөдөө зориулж баатарлагаар амиа алджээ. Эх орныхоо газар шорооны төлөө монгол цэрэг яаж амиа золиосолж чаддагийн үлгэрлэлийг үзүүлж ийнхүү хоёр залуу амиараа баатарлаг үйлсийг бүтээж, залуу насаа мөнхөлсөн түүхтэй.

Салааны дарга Б.Очир өөрийн салаатай хоёр удаа дайсны байрлалын гүнд тагнуулын үүргийг гүйцэтгэж, япончууд цэргийн их хүчээр дайрахаар бэлтгэж байгаа тухай гарцаагүй мэдээллийг ямар их үнэ цэнээр олсныг, үүнд нийтлэлийн баатар Б.Дэмчиг гол үүрэг гүйцэтгэж байсан нь мэдрэгддэг.

дайчаас баатарлаг үйлс бүтээж гавьяа байгуулсан хүн олон. Тухайлбал, сумангийн ХЗЭ-ийн үүрийн болон тасгийн дарга Балдангийн Дэмчиг, Батын Самбуу, Дэмбэрэлийн Баасанхүү, Өвөрхангайн Гэндэнгийн Ёндонжамц, Архангайн Шагдарын Ерэнтэй, Завханы Цагааны Дандгай, Гомбын Дорж, Архангайн Баатар, Увсын Хаваг, Ховдын Цэндийн Олзвой (БНМАУ-ын баатар болсон)-г онцолж болно.

1939 оны 3 дугаар сарын эхээр заставын тасгийн дарга Н.Жамбаа 10 хүнтэй тасгаараа Өндөр улаан манханд харуулд гараад өглөөний 04.00 цагаас дайсны 60-аад хүнтэй хоёр салаанд бүслэгдэн байлдаж эхлэхэд Эмээлт, Талын манханы харуулд үүрэг гүйцэтгэж байсан Б.Очир даргатай салааныхан мэдээд дайсны араас довтолж нөхдөө хохиролгүй гаргаж байжээ. Тавдугаар сарын эхээр голын мөс ханзарч, уулын цас хайлан урсаж, эх голдоо нийлэн Халхын гол эргээ халин оволзож, мориор гатлах боломжгүй болсон байна. Байгалийн энэ бэрхшээлийг дайсан овжин ашиглаж Хайлаастын гол, Талын манханаар 5-10 км-ийн гүнд нэвтэрч харуулууд руу өдөр болгон толгой өндийлгөхгүй буудаж цагийн байдлыг маш хүндрүүлсэн учир цэргийн дээд командлал, дивиз, отрядын удирдлагад энэ тухай сумангийн дарга Д.Шарав, заставын дарга П.Чогдон нарыг илтгэхэд, “... 6 дугаар морьт дивизийг яаралтай хөдөлгөөн. 15-21-ний өдрийг хүртэл зургаа хоног дайсны хүчийг одоо байгаа зааг дээр нь барьж бай” гэж тушаасан байна. Ийм цагийн байдалд Д.Шарав нэг тасгийг харуулд үлдээгээд бусад бүрэлдэхүүнээ 15-ны өдрийн шөнө голын цаана гаргав. Нэг хоногийн хүнстэй, морьдыг хоёроор холбон, буугаа хүзүүндээ үүрч голоор хөвүүлэн гаталсан ажээ. 16-ны өглөө гэгээ ороход бүх салаа тогтоосон заагт гарч чадсан байлаа. Сумангийн дарга Д.Шарав, улс төрийн удирдагч Д.Махцэнд нар салаа тасгуудаар явж, үүрэг өгч, ухуулга хийж, зориг, тэвчээртэй, өндөр сонор сэрэмжтэй байж, нэг ч алхам ухрах эрх байхгүй гэж уриалж байлаа. Өглөөнөөс эхлэн дайсныг нүд салгалгүй ширтэж, өдөр шөнөгүй буудалцаж, амь өрсөн тулалдаж тав хонохдоо тэд халуун хоол ундны бараа харалгүй, нойтон элсээр элгээ дэвтээж, шөнийн харанхуйг ажиглан Халхын голын бургасанд байгаа морь баригчдаас авчирч өөрдөг хоёр лааз ус, жаахан мах, нэг уут бөгдөг оор л сумангийн 110 хүн гол зогоож байжээ.

Тавдугаар сарын 20-ны өдрийн шөнө 17 дугаар морьт хорооны хоёр салаа ирж, дээрх аргаар гол гаталсан байна. Шигшмэл суман тусгай үүрэг амжилттай биелүүлжээ. 26-ны өдөр Шигшмэл суманг татан буулгаж хороодод нь тагнуулын салаа болгосон бөгөөд Б.Дэмчиг өөрийн тасагтайгаа 15 дугаар морьт хорооны 2 дугаар суманд хуваарилагдан дайныг дуустал дэслэгч Балдандагвагийн салаанд байлдсан байна.

Баатарлаг үйлс бүтээсэн замын оршил хэсгийг багцлан дүгнэвэл Б.Дэмчиг Дархан уулын хажуугаар Баргын харуулын рашааны хийдийн орчим хүртэл хэд хэдэн удаа Хайлааст манхны орчмыг бүрэн тагнаж ангидаа тагнуулын 10 гаруй мэдээг авчирч, амьд хэл хоёрыг баримт бичгийн хамт олзолсон юм. Ер нь дарга нараас байлдааны хүнд хэцүү даалгаврыг түүнд өгдөг байсан нь түүний эрдэм чадварт нь хэр их итгэж байсны гэрч гэлтэй. Шигшмэл сумангийн тусгай үүрэг гүйцэтгэсэн дөрвөн сарын хугацаанд ХЗЭ-ийн үүрийн даргаар сонгогдсон нь мөр зэрэгцэн албаа хааж байсан дайчин нөхөд нь ч түүнд итгэдэг, хүндэтгэлтэй ханддагийн илрэл бөгөөд дайны үед түүнийг төрийн дээд шагналд тодорхойлсон баримт бичигт энэ тухай тусгасан байдаг.

15 дугаар морьт хорооны 2 дугаар суманд дэслэгч Балдандагвын салаанд байлдаан, тулалдаан, тагнуулын үүрэг гүйцэтгэх туршлагатай Б.Дэмчиг даргатай тасаг ирсэн нь их олзуурхуштай байлаа. Хорооны хаалтын салаанд томилогдон тагнуул, туршуул хийх, дайсан довтолоход туслах хүч иртэл эзэлсэн заагаа найдвартай хамгаалж дарга, цэрэг хамт олныхоо талархлыг хүлээсэн хүн нь бага дарга Б.Дэмчиг байв. 28-ны өдрийн байлдаан эхлэхийн өмнө 27-ны өдрийн шөнө 02.00 цагт салааны дарга Б.Дэмчигийг дуудаж, “... Толгойн сэргийлэхүүд, зэргэлдээ тагнуулын мэдээгээр манай урд чимээ гараад байна. Нөхөр Дэмчиг тасгаасаа хоёр цэрэг авч өндөр элсэн дээр харуулд гарч тагна. Надтай байнга холбоотой бай” гэж тушаажээ.

Тасгаасаа Дорж, Ёндонжамц нарыг аваад гурван километр зайтай байгаа манхан дээр гарвал элсний цаад цагаан хөндийд маш их чимээ гарч, цаанаас нь гэрэлгүй олон машин ойртож ирээд байгаа нь ойлгомжтой байв. Үүр хаяарахад бөөн тоос босож өндөр өвстэй хэсэг талд давших зохион байгуулалтаа хийгээд, гэгээ гарангуут гурван эгнээгээр хоёр хүний хооронд хоёр метрээс илүүгүй зайтайгаар дайсан яг тэдний хороог чиглэн давшиж эхлэв. Тасгийн дарга цэрэг Доржийг хороонд хэл хүргэх үүрэг өгч, Ёндонжамцад хоёр морио баруулан хонхорт нууж, өөрөө буугаа мөрлөн олтолт хийж байтал цаг шахмын дараа дайсны толгойн сэргийлэхийн 16 хүн тулж ирэв. Гэнэт гал нээн найман хүнийг устгахад тэдний бага дарга мэргэн буудагчаа нэр цохон галлуулсан боловч Б.Дэмчиг урдаа өнгөлөн далдлалт бүхий хэд хэдэн байр бэлтгэсэн байсан тул байрлалаа сольж суманд оногдсонгүй. Үлдсэн нь ухарч гол хүчиндээ нийлж дахин давшлаа. Энэ үед Балдандагвын салаатай хорооны сургагч Кравченко, эмнэлгийн албаны дарга Шаравдорж нар ирж дайсны тухай шинэ мэдээ авсны дараа салаатайгаа давшилтад үүргээ сайн биелүүлэв. 28-ны өдрийн тулалдаанд Архангайн Цахир сумын Ёндонжамц дайралт дунд шархдан, мориноосоо салсан боловч, орчиндоо байсан зургаан хүнийг устгаад, баатар дайчны ёсоор амиа алдаж, салааны дарга Балдандагва хүнд шархаджээ. 6 дугаар морьт дивизийн энэ өдрийн тулалдааны хүндийг 15 дугаар морьт хороо үүрч гарсан байдаг.

Б.Дэмчигийг тэргүүний дайчин байсан гэдгийн нэг баталгаа нь 1939 оны 8 дугаар сарын 23-ны өдөр байлдааны галын шугаман дээр МАХН-ын гишүүнээр элссэн явдал. Б.Дэмчиг энэ тухайгаа “Улаан од” сонин 1988 оны 3 дугаар сарын нэгэн дугаарт нийтлэгдсэн ярилцлагадаа “... Бид нуувчиндаа байлаа, манай сумангийн намын гишүүн Отгоны Нанзан миний дэргэд мөлхөж ирээд тасгийн санал сэтгэгдэл ямар байгааг асуугаад, намайг намд элсэх үү хэмээн асуув. Би ч элсэе гэтэл, өргөдлөө бич гэдэг юм байна.Орой сумангийн улс төрийн удирдагч Жамъянгарав, намын гишүүн Нанзан нар миний нуувчинд мөлхөж ирээд намын үүрийн хурал хийж МАХН-д элсүүлэх асуудлыг хэлэлцсэн” хэмээн дурссан байдаг.

Хурлын материалыг нуувч дундуур гишүүдэд дамжуулан уншуулж санал, асуудлыг аван хийж, түүнийг намд элсүүлсэн түүхтэй бөгөөд сумангийн улс төрийн удирдагч Жамъянгарав баяр хүргэж, “Намын гишүүн Б.Дэмчиг та маргааш хамгийн түрүүнд тасгаа удирдан дайралтад ор” гэжээ.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)

Монгол цэргийн музейн ахмад ажилтан, судлаач М.БЯМБАРАГЧАА

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨРТ



Жил бүрийн 3 дугаар сарын 18-ны өдрийг “Цэргийн баяр”, “Зэвсэгт хүчний ойн өдөр”, “Монгол цэргийн өдөр” гэх мэт мэт олон янзаар нэрлэж, тэр ч байтугай “Эрчүүдийн баяр” гэж тэмдэглэсээр ирэв.

Өдгөө энэ баяраа манай цэрэг, дайчид зөвхөн эх орондоо төдийгүй “Дэлхийн цэрэг” болж олон улс даяар энхийг сахин

“ЦЭРГИЙНХ” ҮҮ, “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ” ӨДӨР ҮҮ?

Энд дуртган буй тэмдэглэлт өдрийн нэр, агуулга, цар хүрээ хэд хэдэн удаа солигдон өөрчлөгдөж ирсэн нь дээр өгүүлснээс тодорхой харагдаж байна. Сүүлийн жилүүдэд дээр, дооргүй “Зэвсэгт хүчний төд өдөн жилийн ой” гэх юм уу, эсвэл “Монгол цэргийн

болно. Цэрэг татах үед олон морьтон эрс нэг дор цуглардаг нь тодорхой бөгөөд тэдгээрийн морийг уях шаардлагатай тул хоорондоо нэлээн зайтай хоёр шон босгож сур юм уу дээсээр хоёр шонгийнхоо оройг холбоод мөнхүү зэлнээсээ морьдоо уядаг байсан ажээ. Тийнхүү морины уяа, шонг илэрхийлсэн цэрэг гэдэг үг дэлгэрснээр

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР

хамгаалахын төлөө тэмцлийн галын тэргүүн шугаман дээр угтан золгож байна.

ЦЭРГИЙН БАЯРЫН ТҮҮХИЙН ТОВЧООН

Энэ баяр нь 1921 оны 3 дугаар сард Хиагтад бүгшээд байсан Хятадын гамин цэргийн гол хүч болох 2000 гаруй цэргийг Ардын журамт цэрэг бут цохиж, 7 дугаар сард нийслэл Хүрээг чөлөөлөн төр, засгийн эрхийг Ардын засгийн газарт шилжүүлж, улмаар эх орныхоо баруун, зүүн хязгаарыг цагаантны цэргээс бүрэн чөлөөлж Ардын хувьсгалын ялалтыг дархалсан агуу их түүхээс угшилтай. Анхлан Ардын Засгийн газрын шийдвэрээр 1922 оны 7 дугаар сарын 11-ний өдөр Ардын хувьсгалын ялалтын баярыг тэмдэглэсэн ба түүнээс хойш энэ нь уламжлал болон тогтсон. Үүний хамт мөн жил бүрийн зуны урин цагт “Цэргийн наадам” хийж, Жанжин тугаа Баянзүрх уулнаа тахиж баатарлаг дайчдынхаа алдар сууг дуурсган цэрэг эрсийн наадам, тэмцээн зохиож сур хүчийг түмэн олноо бадраан харуулдаг байв. Ийнхүү төр улсын болон цэргийн наадмыг хоёр тусдаа хийдэг байснаа 1932 оноос хамтатгаж, жил бүрийн 7 дугаар сарын 11-ний өдөр “Цэрэг, ардын наадам” хийдэг болжээ.

Харин Улсын Бага Хурлын 1946 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар хурлын тогтоолоор Ардын журамт цэрэг Хиагт хотыг чөлөөлж анхны ялалтаа байгуулсан 3 дугаар сарын 18-ны өдрийг “Хувьсгалт цэргийн баярын өдөр” болгон жил бүр улс нийтээр ёслол тэмдэглэх шийдвэр гаргажээ. Энэхүү шийдвэрийн дагуу 2003 оныг хүртэл энэ өдрийг “Цэргийн баяр” хэмээн, Улсын наадмаас тусгайлан тэмдэглэх болсон байна.

Чингээд 2003 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулиар жил бүрийн энэ өдрийг “Зэвсэгт хүчний өдөр” хэмээн тэмдэглэхээр болгосон боловч 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдөр мөн хуульд өөрчлөлт оруулж, энэ баярыг “Монгол цэргийн өдөр” гэж хуульчлан нэрийг нь дахин өөрчлөн тэмдэглэх болсон түүхтэй.



өдөр, Зэвсэгт хүчний төдөн жилийн ой” гэж хамтатган нэрлэж ярьж, бичих болов. Гэтэл угтаа бол “Монгол цэрэг” гэвэл нэг өөр, “Зэвсэгт хүчин” гэвэл мөн өөр агуулгатай ухагдахуун юм. Энэ тухай товч дурдвал:

Арми, Тэнгисийн цэрэг, Нисэх хүчин, Хилийн цэрэг,



Дотоодын цэрэг гэх мэт олон ай, төрлийн цэргийг нийлүүлээд нийтэд нь нэрлэх нэр томьёо дэлхийд XIX зууны сүүл хүртэл, Монголд XX зууны 40-өөд он хүртэл байсангүй. Бүгд л тусгай нэрээр нь нэрлэдэг, харин монголчууд бүгдийг “Цэрэг” хэмээх ганц ерөнхий нэрээр нэрлэдэг байж. Тэгэхдээ нэг бодгаль хүнийг ч, төрөл мэргэжлийн цэрэг, армийг ч “Цэрэг” гэдэг. Энэ угтаа одоо ч алдагдаагүй буй.

Дашрамд өгүүлэхэд монголчуудын амьдрал, ахуй, дайтан тулалдах арга ухааны олон зүйл морьтой холбоотой байсанчлан “Цэрэг” гэдэг үгийн гарал ч морьтой холбоотой ажээ. Эрт цагт монгол туургатан овог, аймгийн ноёд, тэргүүнүүд дайн, байлдаан хийхээр зар тарааж олон морьтон дайчдыг нэг дор цуглуулахдаа “Болзоол газар” буюу одоогийн цэргийн хэллэгээр “Цуглаарх байр”-т хүрэлцэн ирсэн дайчдын морийг уях зорилгоор олон шон зэрэгцүүлэн босгодог байжээ. Тэрхүү шонгуудаа “Цэрэг” гэдэг, зарим овгийнхон “Черег”, “Жиргэ”, “Сэрэг (сэргэ)”, “Цэрэв” гэдэг байсан бөгөөд буриад зэрэг зарим монголжин овог угсаатан одоо ч “Цэрэг” гэхийг “Сэрэг” гэж дууддаг.

Нэрт эрдэмтэн Л.Түдэв “Монгол сэргэ” хэмээх бүтээлдээ “Сэргэ гэдэг үгийн гарал үүсэл нь эрт цагийн цэрэг татлагатай холбоотой

барахгүй “Цэрэг татах” гэдэг нэр томьёо буй болж сүүл сүүлдээ татах гэдэг үгийг орхиж “Цэрэг” хэмээн нэрийдэх болжээ. Тэр нь сунжирсаар морины уяанд биш харин хүмүүст шилжиж “Цэрэг татах” гэж олон эрсийг дайн, байлдааны зорилгоор дуудаж цуглуулахын нэр болон

хувирчээ. Түүгээр ч барахгүй цэрэг гэдэг үг нь ч дайчин эрсийг хэлэх ойлголт болжээ хэмээсэн байх ба чанагш өгүүлэхдээ: “Цэрэг буюу сэргэ гэдгийн хоёр дахь утга нь Якутад эгнээ (зэргэ), буриадад зэргэ (эгнээ), монголд зэргэ, түрэгт арга (эгнээ) гэхчлэн эгнэн жагссан цэргүүдийг юм уу хөлөг морьдыг санагдуулах ойлголт буй” болсон гэжээ.

Харин “Зэвсэгт хүчин” гэх нэр томьёоны тухайд бол Германы суут сэтгэгч, цэргийн онолч Ф.Энгельсийн “бүтээл” бөгөөд тэр бээр XIX зуунд арми, флотыг хамруулсан ерөнхий нэршлийн хэлбэрээр “Зэвсэгт хүчин” хэмээх ухагдахууныг анх томьёолж шинжлэх ухааны эргэлтэд оруулсан нь дэлхий дахинаа түгэн тархсан түүхтэй билээ.

Монгол Улсад “Зэвсэгт хүчин” гэх томьёоллыг албан ёсоор анх 1940-өөд оноос хэрэглэх болсон бөгөөд 1944 онд батлагдсан “БНМАУ-ын Ард нийтээс цэргийн албыг хаах үүргийн тухай хууль”-д “БНМАУ-ын Зэвсэгт хүчин нь Ардын хувьсгалт цэрэг, Хязгаарын ба дотоодын цэргээс бүрдэнэ” гэж заасан байв. Ийнхүү Монголд “Зэвсэгт хүчин” анх албан ёсоор буй болсон байна. Өөрөөр хэлбэл, энэ үеэс “Цэрэг” гэдэг ерөнхий нэрээс ангид тусдаа “Зэвсэгт хүчин” гэдэг ухагдахуун монгол цэргийн хэрэгт бий болжээ.

2016 онд батлагдсан Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын баримт бичигт тусгагдсанаар өнөөгийн Монгол Улсын Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг, төрөл мэргэжлийн бусад цэргээс бүрдэж байгаа. Дайны байдлын үед бол Зэвсэгт хүчний бүтцэд тэдгээрээс гадна Хилийн ба Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллага орж байлдааны үүрэг гүйцэтгэх учиртай.

Тиймээс “Цэрэг”, “Зэвсэгт хүчин” хэмээх хоёр ухагдахууны чанадын утга, агуулгыг бид ялгаж, салган ойлгох учиртай ажээ.

“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”

Энэ өдрийг бид зөвхөн Ардын цэргийн баяр юм уу, “Зэвсэгт хүчний ойн өдөр” болгон

явцууруулж тэмдэглэсээр ирсэн, тэгэхдээ голдуу 1921 оноос эхлэн тооцож “төд, өдөн жилийн ой” гэж цохон дурдсаар ирэв.

Тэгвэл Монголд цэрэг чухам хэдийд үүссэн юм бэ? Түүний үүслийг 2200 гаруй жилийн өмнө Хүннүгийн үеэс тооцох уу, дэлхий дахиныг илбэн тохиуулсан Чингис хааны үеэс

нь Монголын Хиан аймаг бөгөөд хятад тулгар бичгүүдэд Хианыг “Сянь Юнь (khiyan)” гэж тэмдэглэсэн байдаг ажээ.

Өвөр Монголын нэрт түүхч тайчууд Мансангийн эрхлэн гаргасан “Монгол үндэстний бүрэн түүх” хэмээх зургаан боть бүтээлд монголчуудын өвөг дээдсийн байгуулсан анхны төрт



улс болох “Хиан улс нийтийн тооллын өмнөх (чанагш НТӨ гэнэ) 2033 оноос НТӨ 1562 он болтол 471 жил, түүний халааг авсан Бидгүд улс НТӨ 1562 оноос НТӨ 1066 он болтол нийт 496 жил оршин тогтносон”-ыг Хятадын эртний сурвалж

БА ТҮҮХ СӨХӨХҮЙ

тоолох уу, эсвэл 1911 оноос юм уу, 1921 оноос эхлэн тоолох ёстой юу, Анх хуульд нэршиж орсноор нь 1944 оноос үүдэлтэй гэж үзэх үү.

Хүннүгийн үеэс гэвэл түүнээс өмнө төрт улс, цэрэг гэж байгаагүй, монгол үндэстэн буй болоогүй байсан юм уу. Өмнөд хөрш Хятад улс гэхэд 5000

бичгүүдийн мэдээ, эртний судлалын баримтад тулгуурлан нотолж тодорхойлсон байна. НТӨ 1066 оноос хүннүгүүд өвөг дээдсийнхээ төр, цэргийн уламжлалд тулгуурлан туурга тусгаар улс гэрээ төвхнүүлж эхэлжээ.

Ийнхүү “Монгол цэрэг”-ийн талаарх хамгийн эртний мэдээ



жилийн түүхтэй гэж албан ёсоор зарлачихсан. Монголчууд тэр үед улс гэрээ байгуулах чадваргүй байсан уу гэх мэт олон асуулт гарч ирнэ.

Гэтэл түүх сөхөөс Монгол орон ухаант хүмүүн үүссэн өлгий нутгийн нэг бөгөөд монгол үндэстэн аль эрт, одоогоос 8000 жилийн тэртээ тусгаар үндэстний хувьд нэгэнт бүрэлдэн тогтносон, Хүннү гүрэн байгуулагдахаас тэртээ өмнө анхны төрт улсаа байгуулсан ажээ. Тухайлбал, өдгөөгөөс 5000 жилийн өмнө Хятадын Хуан Ди гэгч хаан Хятад улсыг үндэслэн байгуулж байх үед түүнтэй эн тэнцэхүйц хүчтэй, гол нэгэн өрсөлдөгч умар зүгт оршин байсан нь монголчуудын өвөг болох Хунь Юй гэгч хаан байсан нь түүхнээ тодорхой тэмдэглэгджээ. Жич: Хунь Юй гэх нэрийн хувьд бол хятадчилан тэмдэглэсэн нэр болох нь ойлгомжтой. Эртний монгол үгийг эртний хятад ханзаар тэмдэглэснийг хэрхэн тайлж уншихаас аялга дуудлагын ялгаа, зөрөө гарна. Тийм учраас Хунь Юй гэж тэмдэглэгдсэн нэрийн угшил монголоороо чухам ямархуу үг байсан нь хойшдын судалгааны явцад тодорхой болох буй за.

Хятадын түүхийн сурвалж бичгүүдэд монголчуудын тэрхүү өвөг Хунь Юй, Хятадын өвөг Хуан Ди нар цөөн бус удаа их цэргээр дайлагдаж харилцан ялж, ялагдаж байсан тухай тодорхой өгүүлсэн байдаг ажээ.

Сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс харахад Монголын түүхэнд хамгийн анхны төрт улс буюу “төр төст” улсыг байгуулсан

цаг хугацааны хувьд одоогоос 5000 орчим жилийн өмнөх үетэй холбогдож байна.

БАЯР ТЭМДЭГЛЭХҮЙ

2011 оноос эхлэн жил бүрийн 3 дугаар сарын 18-ны өдөр тэмдэглэх болсон “Монгол цэргийн өдөр” нь зөвхөн Зэвсэгт хүчнийхний юм уу, Ардын цэргийнхний баяр төдий бус гэдгийг дээр дурдсан бүхэн бэлхнээ илтгэн харуулж байна. Тиймээс энэ баяр нь Монголын бүх цэргийн баярын өдөр, энэ өдөр Зэвсэгт хүчнийхэнд ч, мөн тайван цагт Зэвсэгт хүчний бүтцэд багтдаггүй Хилийн цэргийнхэнд ч, Дотоодын цэргийнхэнд ч, “Онцгойгийнхонд” ч, ерөөсөө цэргийн мөрдэс зүүсэн эрэгтэй, эмэгтэй бүх хүнд, тэдний ар гэрийнхэнд ч хамаатай баярын өдөр гэдгийг эцэст нь онцолж байна.

Нөгөөтэйгүүр “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэхдээ гагцхүү XX зуунаар хязгаарлалгүйгээр, өрлөг түүхийн бүхий л үеийг харгалзаж, эрт цагаас инагш улс орныхоо тусгаар тогтнолыг зөвхөн халуун амиараа төдийгүй цэргийн эрдэм чадал, суу билгийнхээ хүчээр хамгаалан тэмцэж, хүн төрөлхтний түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн агуу дайчин өвөг дээдэс, үе үеийн цэрэг дайчдынхаа алдрыг улам бүр өргөн дээдэлж, бахархан дуурсах өдөр хэмээхийг хэзээд ч мартаж үл болно.

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор, профессор Ж.БАЗАРСҮРЭН